



ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны Санхүүгийн Тайлан

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248 дугаарын утаснаас лавлана уу?

Дарга, Тэргүүлэх аудитор
Л.Жаргалсайхан
өрөөний утас 70272582

Аудитын менежер
О.Амаржаргал
өрөөний утас 70273465

Шинжээч
Ц.Хишигжаргал
Өрөөний утас 70273204

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

**Төв аймгийн Өндөрширээт сумын төсвийн байгууллагууд,
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Өндөрширээт сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Өндөрширээт сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

- Орон нутгийн төсвийн татварын орлогыг 46780.0 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 46974.4 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 194.4 мянган төгрөгөөр буюу 101 хувиар биелүүлсэн байна.
- Сум хөгжүүлэх санд нийт 100000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ХЭДСангаас 50000.0 мянган төгрөг, аймгийн сум хөгжүүлэх сангаас 50000.0 мянган төгрөг тус тус санхүүжүүлсэн байна.
- Сум хөгжүүлэх сангийн 2013 оноос өмнөх авлагад С.Өлзий сайханд 2012.7.6-нд олгосон 15.0 сая төгрөгнөөс үндсэн зээл болон хүүгийн төлөлт огт хийгдээгүй нь дээрх авлагын 67.4 хувийг эзэлж байгаа тул энэ зээлийн төлөлтөнд анхаарах шаардлагатай байна.
- Байгал орчныг нөхөн сэргээх санд “Байгаль хамгаалах сан”-д орох 11698.2 мянган төгрөгний санхүүжилтийг оруулж, байгаль хамгаалах чиглэлийн арга хэмжээнд 5777.1 мянган төгрөг зарцуулж, оны эцэст 6598.1 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна. энэ санд зөвхөн Нөхөн сэргээлтийн барьцааг байрлуулах ёстой ба үлдэгдлүүдийг

компанийн нэрсээр ялгаж бүртгэх
шаардлагатай байна.

*Ерөнхий менежер болон
Санхүүгийн албанаас, ҮАГазрын харьяа
Төв аймгийн Аудитын Газар тайлбар
мэдүүлэг хүлээж байгаа илэрсэн алдааг
хэрхэн залруулсан талаар тайлбар
ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж
авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх
зөрчлүүд материаллагын урьдчилан
тогтоосон түвшингээс бага тул **Зөрчилгүй
санал** дүгнэлт гаргахаар Тэргүүлэх
аудитор санал хүргүүлсэн байгаа.

- ҮАГазрын харьяа Төв аймгийн
Аудитын Газрын дарга, Тэргүүлэх
Аудитор 2014.03.24-ны өдөр санал
дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч,
нярав болон бусад албан тушаалтан
бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд
дэмжлэг болж байсанд гүнээ талархаж
байна.

**ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

2014.03.21

Танилцуулга

Өндөрширээт сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Өндөрширээт сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Өндөрширээт сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Өндөрширээт сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Өндөрширээт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12-р сарын -ний өдрийн -р хуралдааны -р тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 46780.0 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 46974.4 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 194.4 мянган төгрөгөөр буюу 101 хувиар биелүүлсэн байна.

Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 62010.9 мянган төгрөг, гүйцэтгэлээр 64498.3 мянган төгрөг буюу биелэлт 104 хувьтай, улсын төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөгөөр 1100.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 4204.9 мянган төгрөг биелэлт 3.8 дахин биелсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 12311.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 46974.4 мянган төгрөг төвлөрсөн ба НЕҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 339609.0 мянган төгрөг, нийт 386583.4 мянган төгрөг төвлөрч, санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 189154.6 мянган төгрөг, ИТХуралд 36960.5 мянган төгрөг, Багт 35582.1 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс ЗДТГазарт 48186.5 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 353843.1 мянган төгрөг, Цэцэрлэгт 101363.7 мянган төгрөг, Эмнэлэгт 190784.3 мянган төгрөг, Соёлын төвд 58015.4 мянган төгрөг нийт 704006.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг нэгтгэсэн байна. НЕҮйлчилгээний байгууллагуудын оны эхний харилцах дансны үлдэгдэл 461.5 мянган төгрөгийг болон төсөвт байгууллагуудын эцсийн зарцуулаагүй үлдэгдэл 9545.1 мянган төгрөгийг НЕҮйлчилгээний үлдэгдэл 1413.6 мянган төгрөг халамжийн сангийн үлдэгдэл 1905.2 мянган төгрөг нийт 12863.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна

Халамжийн сангийн санхүүжилт 115947.2 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 82327.0 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 24460.0 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 6570.0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 685.0 мянган төгрөг зарцуулсан байна. үлдэгдэл 1905.2 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 11968.7 мянган төгрөг, Сургууль 1327.2 мянган төгрөг, ЭМТөв 30.0 мянган төгрөг нийт 13325.9 мянган төгрөгийн орлого, 13295.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 30.0 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнагдсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Тамгын газарт 5623.2 мянган төгрөг, Соёлын төв 379.7 мянган төгрөг, ЭМТөв 400.0 мянган төгрөг, нийт 6402.9 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Сум хөгжүүлэх санд нийт 100000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ХЭДСангаас 50000.0 мянган төгрөг, аймгийн сум хөгжүүлэх сангаас 50000.0 мянган төгрөг тус тус санхүүжүүлсэн байна.

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд ЗДТГазар 6289.7 мянган төгрөг, ИТХурал 35.2 мянган төгрөг, Баг 12.3 мянган төгрөг нийт 6337.2 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 16647.0 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 12311.7 мянган төгрөг, эргэлтийн эмийн сан 6821.5 мянган төгрөг нийт 42117.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 56376.7 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 5475.9 мянган төгрөг, эргэлтийн эмийн сан 5290.8 мянган төгрөг, Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 30.0 нийт 67143.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаатай тохирч байна.

Авлага, өглөгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд 106845.4 мянган төгрөгийн авлага, оны эцэст 268755.5 мянган төгрөгийн авлагатай нэгтгэгдсэн ба оны эхнээс авлага 162295.5 мянган төгрөгөөр өссөн ба жилийн эцсийн нийт авлагын 98 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 266280.9 мянган төгрөг эзэлж байна.

Өглөгө оны эхэнд 539.9 мянган төгрөг, оны эцэст 3777.4 мянган төгрөгийн өглөгтэй нэгтгэгдсэн байна. Оны эцэст Сургуулийн цалингаас суутгасан 2307.8 мянган төгрөг нь нийт өглөгийн 61 хувийг эзэлж байна

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 71380.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд худалдаж авсан 170010.2 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс 4026.5 мянган төгрөг нийт 174487.7 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж,

168214.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 77654.4 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 3764747.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд худалдаж авсан 1292.5 мянган төгрөг, хандив тусламжаар 120116.9 мянган төгрөг нийт 121409.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, жилийн эцэст 2247342.5 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Тусгай зориулалтын сангууд

Сумын хэмжээнд 7 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

Байгаль хамгаалах сангийн талаар:

Байгаль хамгаалах санд оны эхэнд 538.0 мянган төгрөгний үлдэгдэлтэй. 2013 онд хогны хураамжаар 144.0 мянган төгрөг орсон, шатахууны үнэнд 55.0 мянган төгрөгний зардал гарч, оны эцэст 627.0 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд оны эхэнд үлдэгдэлгүй, 2013 онд төсвөөс 130523.4 мянган төгрөгний санхүүжилт, хандиваар 1000.0 мянган төгрөг бүгд 131523.4 мянган төгрөгний орлого орж, нийт 12130.0 мянган төгрөгний төсөвт өртөгтэй 8 ажилд 94419.9 мянган төгрөгний санхүүжилт хийгдэж, сангийн дансанд оны эцэст 36903.5 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

Худгийн засварт Арвин ар шанд хоршоо 4500.0 мянган төгрөг, Сумын төвийн гэрэлтүүлэгт Уулын хаан үрс ад ТББ 7000.0 мянган төгрөг, Хогийн цэгийн хашаа барихад С.Гансүхэд 2800.0 мянган төгрөг, Брайт пэйнт ХХК-д 19615.7 мянган төгрөг, Морь барианы газрын засварт Д.Батэрдэнэд 1600.0 мянган төгрөг, Наадмын зардалд 5000.0 мянган төгрөг, Ногоон байгууламж барихад 11130.0 мянган төгрөг, Зураг төсөлд 7650.0 мянган төгрөг, трактор авахад 33530.0 мянган төгрөг, арьс ширний цехийн цахилгааны зардалд 1194.2 мянган төгрөг нийт 94419.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөн зарим төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт буюу 35.1 мянган төгрөгийн өглөгтэй гэж тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.6-д орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно гэсэн заалтыг зөрчсөн байна

Мал хамгаалах сангийн талаар:

Мал хамгаалах санд оны эхэнд 3228.6 мянган төгрөгний үлдэгдэлтэй, 2013 онд тэжээл борлуулсаны орлогоор 5624.0 мянган төгрөгний орлого орж, өвс худалдан авахад 3600.0 мянган төгрөг, шатахууны зардалд 450.0 мянган төгрөг, бүгд 4050.0 мянган төгрөгний зардал гаргаж, оны эцэст 3802.5 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна. Тухайн санд байгаа бараа материал буюу өвс, тэжээлийн бүртгэл, тооллого хийж тооцоо бодсон актууд байгүй байна.

Сүм хөгжүүлэх сангийн талаар:

Тус санд оны эхэнд 11348.0 мянган төгрөгний үлдэгдэлтэй, 2013 онд аймгаас тус санд 100000.0 мянган төгрөгний хөрөнгө нэмж санхүүжүүлсэн, зээлдэгч нараас тайлант онд 57884.2 мянган төгрөгний зээл, хүү төлөгдсөн, 161000.0 мянган төгрөгний зээл олгосон оны эцэст санд 7894.4 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна. Нягтлан бодогчийн хийсэн тооцоогоор өмнөх оны зээлийн болон хүүгийн төлөгдөөгүй авлага 2013 оны эцэст үндсэн зээл 20332,3 мянган төгрөг,

зээлийн хүүгийн авлага 2906.4 мянган төгрөг, бүгд 23238.7 мянган төгрөгний байна. /2013 онд олгосон зээл, хүүгийн авлага ороогүй/

Сум хөгжүүлэх сангийн 2013 оноос өмнөх авлагад С.Өлзий сайханд 2012.7.6-нд олгосон 15.0 сая төгрөгнөөс үндсэн зээл болон хүүгийн төлөлт огт хийгдээгүй нь дээрх авлагын 67.4 хувийг эзэлж байгаа тул энэ зээлийн төлөлтөнд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Байгаль орчин нөхөн сэргээлтийн сангийн талаар:

Энэ дансанд оны эхэнд 677.0 мянган төгрөгний үлдэгдэлтэй. 2013 онд аймаг, сумаас сумын “Байгаль хамгаалах сан”-д орох 11698.2 мянган төгрөгний санхүүжилтийг оруулж, байгаль хамгаалах чиглэлийн арга хэмжээнд 5777.1 мянган төгрөг зарцуулж, оны эцэст 6598.1 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна. энэ санд зөвхөн Нөхөн сэргээлтийн барьцааг байрлуулах ёстой ба үлдэгдлүүдийг компанийн нэрсээр ялгаж бүртгэх шаардлагатай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн талаар:

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санхүүжилтийн дансанд оны эхэнд 855.3 мянган төгрөгний үлдэгдэлтэй, 2013 онд 454.9 мянган төгрөгний санхүүжилт олгогдож, 759.0 мянган төгрөгний зардал гаргажээ. Оны эцэст 551.2 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

Данснаас мэдээллийн самбар хийлгэхэд 70.0 мянган төгрөг, зургийн аппарат авахад 150.0 мянган төгрөг /аппаратыг ЗДТГазрын дансанд авчээ/, уралдаан тэмцээнд 330.0 мянган төгрөг, томилолтонд 209.0 мянган төгрөгний зардлууд гарсан байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
- Санхүүгийн тайлан гаргалт уялдаа холбоог сайжруулах
- МУ-ын ЗГазрын 2012.11.09-ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.22